

АТГ-ын дарга, ҮСХ-ны даргын  
2009 оны 06 сарын 23-ны өдрийн  
76 / (01/69) тоот хамтарсан  
тушаалын хавсралт

# **АВЛИГЫН ИНДЕКСИЙГ ТООЦОХ АРГАЧЛАЛ**

**УЛААНБААТАР ХОТ  
2009 ОН**

## АГУУЛГА

- I. **НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**
- II. **АВЛИГЫН ИНДЕКСИЙГ ТООЦОХОД АШИГЛАГДАХ ҮЗҮҮЛЭЛТИЙН ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ**
- III. **АВЛИГЫН ИНДЕКСИЙГ ТООЦОХОД БАРИМТЛАХ ЗАРЧИМ, ДАРААЛАЛ, МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР**
  - III.1. Авлигын индекс тооцох дараалал
  - III.2. Авлигын индекс тооцоход шаардлагатай мэдээллийн эх үүсвэр
  - III.3. Олон нийтийн төсөөллийн судалгааны зорилго, хамрах хүрээ
  - III.4. Шинжээчдийн төсөөллийн судалгааны зорилго, хамрах хүрээ
  - III.5. Төрийн байгууллагын авлигын эрсдлийн үнэлгээний судалгааны зорилго, хамрах хүрээ
  - III.6. Баримтын судалгааны зорилго, хамрах хүрээ
- IV. **АВЛИГЫН ИНДЕКС, ТҮҮНИЙГ ТООЦОХ АРГА ЗҮЙ**
  - IV.1. Авлигын цар хүрээний үзүүлэлт
  - IV.2. Авлигын хэлбэрийн үзүүлэлт
  - IV.3. Авлигын индексийг нэгтгэн тооцох арга зүй
- V. **АВЛИГЫН ИНДЕКСИЙН ҮР ДҮНГ АШИГЛАХ, НИЙТЭД ТАРХААХ**

## ХАВСРАЛТ

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

“Авлигын эсрэг” Монгол Улсын хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-т “авлигын хэлбэр, цар хүрээ, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авлигын индекс гарган олон нийтэд мэдээлэх” нь урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндсэн 7 чиг үүргийн нэг гэж заасан.

Түүнчлэн УИХ-ын 2008 оны 13 дугаар тогтоолоор Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтуудын шалгуур үзүүлэлтүүдийг шинэчлэн баталсан. “Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон хэвшүүлэх” гэсэн 24 дүгээр зорилтын хүрээнд авлигын индекс; улс төр, хууль хяналтын хүрээнд дэх авлигын талаарх төсөөлөл; төрийн захиргаа болон үйлчилгээний байгууллагын хүрээн дэх авлигын талаарх иргэдийн төсөөлөл гэсэн 3 үзүүлэлтээр Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон хэвшүүлэх ажлын хэрэгжилтийг үнэлэхээр заасан.

Авлигын индексийг тооцож мэдээлэх нь авлигын эсрэг үйл ажиллагааны бодлого, хөтөлбөрийг боловсруулахад ашиглах; авлигын эсрэг үйл ажиллагааны бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлж дүгнэх; олон нийтийг авлигын эсрэг үйл ажиллагааны талаарх мэдээллээр хангах ач холбогдолтой.

Монгол Улсын авлигын индекс нь авлига хэмээх гэмт явдлын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг тодорхойлох тоон болон чанарын үзүүлэлтүүдийн нийлбэр цогц юм. Өөрөөр хэлбэл, Авлигын индексийг авлигыг хэмжих, тодорхойлох үзүүлэлтүүдийн нэгдсэн цогц гэж товчоор тодорхойлж болно.

## ХОЁР. АВЛИГЫН ИНДЕКСИЙГ ТООЦОХОД АШИГЛАГДАХ ҮЗҮҮЛЭЛТИЙН ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Авлигын индекс тооцох аргачлалд хэрэглэгдэж буй ойлголт, тодорхойлолтыг дараах байдлаар ойлгоно. Үүнд:

“*Авлига*” гэдэгт “Авлигын эсрэг” Монгол Улсын хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг;

“*Эрх зүйн зөрчил*” гэдэгт аливаа гэмт хэрэг, захиргааны эрх зүйн зөрчлийн нийлбэр цогцыг;

“*Гэмт хэрэг*” гэдэгт Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг;

“*Захиргааны зөрчил*” гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр буюу тухайн нутаг дэвсгэрт дагаж мөрдүүлэхээр тогтоосон захиргааны журам санаатай буюу болгоомжгүйгээр зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг;

“*Индекс*” гэдэгт нийгэм, эдийн засгийн үзэгдлийн шууд харьцуулах боломжгүй тоо баримтуудыг харьцуулагдах хэлбэрт хөрвүүлэн цаг хугацаа, орон зайн доторхи өөрчлөлтийг илэрхийлсэн харьцангуй үзүүлэлтийг;

“*Авлигын индекс*” гэдэгт тодорхой нутаг дэвсгэр (аймаг, нийслэл), төрийн захиргааны байгууллага (яам, агентлаг) дахь авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг тодорхойлох тоон болон чанарын үзүүлэлтүүдийн нийлбэр цогц;

“*Цар хүрээ*” гэдэгт авлигын тархалтын хэмжээ, давтамжийг;

“*Хэлбэр*” гэдэгт авлигын илрэн гарах байдлыг;

“*Шалтгаан*” гэдэгт авлигад нөлөөлөх хүчин зүйлийн цогц ойлголтыг;

“*Байгууллагын авлигын эрсдэл*” гэдэгт тухайн байгууллагад авлига тохиолдох боломжийг;

“*Гэмт хэргийн сэдэлт*” гэдэгт гэмт хэрэг үйлдэхэд шууд нөлөөлсөн дотоод шалтгаан буюу гэмт хэргийн бүрэлдүүний субъектив талын шинжийг;

“*Гэмт хэргийн ангилал*” гэдэгт гэмт хэргийг нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан тодорхой зэрэглэлд оруулсан байдлыг;

“*Гэмт хэргийн давталт*” гэдэгт Эрүүгийн хуулийн нэг зүйл, түүний нэг хэсэгт заасан гэмт хэргийг хоёр буюу түүнээс дээш удаа үйлдэхийг;

“*Давхар объектоой гэмт хэрэг*” гэдэгт гэмт хэргийн явцад Эрүүгийн хуулиар хамгаалагдсан, хоёр болон түүнээс дээш эрх ашигт гэм хор учруулсан буюу учруулж болох байсныг ойлгоно.

## **ГУРАВ. АВЛИГЫН ИНДЕКСИЙГ ТООЦОХОД БАРИМТЛАХ ЗАРЧИМ, ДАРААЛАЛ, МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР**

Авлигын индексийг дараахь зарчмыг баримтлан тооцно. Үүнд:

1. Үзүүлэлтүүд өөр хоорондоо холбоо хамааралтай байх;
2. Шинжлэх ухааны үндэслэл бүхий нэгдмэл арга зүйтэй байх;
3. Мэдээллийн эх үүсвэр тодорхой, мэдээлэл нь тогтмол, үнэн бодитой байх;
4. Үндэсний түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн байх;
5. Хэмжих боломжтой, тодорхой үзүүлэлтүүдийг сонгосон байх;
6. Мэдээлэгчийн нууцыг чандлан хадгалах зэрэг болно.

### **III.2. Авлигын индекс тооцох дараалал**

Авлигын индексийг дараахь дарааллын дагуу тооцно. Үүнд:

1. Олон нийт, шинжээчдийн төсөөллийн судалгаа болон байгууллагын авлигын эрсдлийн үнэлгээний судалгааг явуулж дүнг нэгтгэх, мэдээллийг холбогдох хууль хяналтын байгууллага болон АТГ-ын холбогдох хэлтсээс хүлээн авч баримтын судалгааг хийх;
2. Холбогдох мэдээллийг шалгаж нэгтгэн, авлигын цар хүрээ, хэлбэрийн үзүүлэлтүүдийг тооцох;
3. Авлигын цар хүрээ, хэлбэрийн нэгдсэн үзүүлэлтүүдийг тооцох;
4. Авлигад нөлөөлж буй шалтгааныг тодорхойлох;
5. Авлигын цар хүрээ, хэлбэрийн үзүүлэлтүүдийг нэгтгэн авлигын индексийг тооцох;
6. Авлигын индексийн өөрчлөлт, бүрэлдэхүүн хэсэгт дүн шинжилгээ хийх, холбогдох танилцуулга тайлбарыг бэлтгэх зэрэг болно.

### **III.2. Авлигын индексийг тооцоход шаардлагатай мэдээллийн эх үүсвэр**

Авлигын индексийг тооцоход дараахь дөрвөн үндсэн мэдээллийн эх үүсвэрийг ашиглана. Үүнд:

1. Олон нийтийн төсөөллийн судалгааны үр дүн
2. Шинжээчдийн төсөөллийн судалгааны үр дүн
3. Баримтын судалгааны үр дүн
4. Төрийн байгууллагын авлигын эрсдэлийн үнэлгээний судалгааны үр дүн зэрэг болно.

### **III.3. Олон нийтийн төсөөллийн судалгааны зорилго, хамрах хүрээ**

Олон нийтийн төсөөллийн судалгааны зорилго нь олон нийт (иргэд, төрийн албан хаагч, бизнес эрхлэгчид)-ийн авлигын талаарх төсөөлөл, авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгаан, авлигын тохиолдлууд, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн зэрэг бусад мэдээллийг цуглуулна. Олон нийтийн төсөөллийн судалгааг авлигын индекс тооцон гаргах хугацаанд буюу хоёр жил тутам нэгээс доошгүй удаа явуулна. Судалгааны хамрах хугацаа нь судалгаа явуулж буй хугацаанаас өмнөх сүүлийн 12 сарын хугацааг хамарна.

Олон нийтийн төсөөллийн судалгааны хамрах хүрээг иргэд, төрийн албан хаагч, бизнес эрхлэгч гэсэн гурван бүлэгт хуваан авч үзнэ. Олон нийтийн судалгаанд хамрагдах иргэд, төрийн албан хаагч, бизнес эрхлэгчид нь олон нийтийн төсөөллийн судалгааны нэгж болно.

Иргэдийн төсөөллийн судалгааны үндсэн нэгж нь Монгол Улсад оршин суугаа 18 болон түүнээс дээш насны иргэд байна.

Төрийн албан хаагчдын төсөөллийн судалгааны үндсэн нэгж нь Монгол Улсын Төрийн албаны хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасан “Төрийн албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа...”, мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан ангилалд багтах төрийн улс төрийн, төрийн захиргааны, төрийн тусгай, төрийн үйлчилгээний албан хаагчид байна.

Монгол Улсын Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 25.2-д заасан “Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг ... ашиг олох зорилготой ашгийн төлөө... зохион байгуулалтын нэгдлийн...” буюу хуулийн этгээд, түүнчлэн дээрх байдлаар аж ахуйн зохион байгуулалтад ороогүй хувиараа хөдөлмөр эрхлэгчид нь бизнес эрхлэгчдийн судалгааны үндсэн нэгж болно.

Олон нийтийн төсөөллийн судалгааны түүвэрлэлтийг хоёр түвшинд хийнэ. Түүвэрлэлтийн эхний шатанд аймаг, нийслэлээс судалгаанд хамрагдах сум, дүүргийг сонгоно. Тухайн аймгийн төвийн сум болон нийслэлийн дүүргүүдийг нэлэнхүй байдлаар бүгдийг нь, бусад сумдаас хүн амын тоо, нягтрал зэргийг харгалзан үзэж сонгоно.

Судалгааны түүвэрлэлтийн хоёрдахь шатанд судалгаанд хамрагдах нэгж буюу иргэд, төрийн албан хаагчид, бизнес эрхлэгчдийг сонгоно.

Төрийн албан хаагчдын болон бизнес эрхлэгчдийн судалгаанд хамрагдах нэгжийг тухайн салбарт ажиллаж буй албан хаагчдын тоо болон тухайн салбарт үйл ажиллагаа явуулж буй нэгжийн тоонд үндэслэн бүлэглэсэн пропорцианаль магадлалт түүврийн аргаар сонгоно.

### **III.4. Шинжээчдийн төсөөллийн судалгааны зорилго, хамрах хүрээ**

Шинжээчдийн төсөөллийн судалгааны зорилго нь тодорхой нутаг дэвсгэр (аймаг, нийслэл), төрийн захиргааны байгууллага (яам, агентлаг) дахь авлигын цар хүрээ, авлигын хэлбэр, шалтгаан, эдийн засгийн хор уршиг зэргийг тодорхой шалгуураар сонгосон шинжээчдээр үнэлүүлэхэд оршино. Шинжээчдийн төсөөллийг тоон утгаар буюу үнэлгээний дундаж оноогоор илэрхийлнэ. Шинжээчдийн төсөөллийн судалгааг авлигын индексийг тооцох хугацаанд буюу хоёр жил тутам нэгээс доошгүй удаа явуулна. Судалгааны хамрах хугацаа нь судалгаа явуулж буй хугацаанаас өмнөх сүүлийн 12 сарын хугацааг хамарна.

Төрийн захиргааны төв байгууллага, тэдгээрийн салбар, нэгж; нутгийн өөрөө удирдах байгууллага буюу аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын ажлын алба буюу тамгын газрыг судалгаанд хамруулна.

Судалгааны нэгжийг дараах байгууллагаас сонгоно. Үүнд:

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
2. Яам, агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн засаг даргын тамгын газар
3. Шүүх, прокурор, цагдаагийн байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага
4. Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж
5. Төрийн бус байгууллага зэрэг болно.

### **III.5. Төрийн байгууллагын авлигын эрсдлийн үнэлгээний судалгааны зорилго, хамрах хүрээ**

Төрийн байгууллагын авлигын эрсдлийн үнэлгээгээр */цаашид өөрийн үнэлгээ гэнэ/* авлига үүсгэж буй хүчин зүйл, нөхцөл байдлыг тодорхойлно. Өөрийн үнэлгээгээр төрийн байгууллагуудын хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх үйл явц, тэдгээрийн үйл ажиллагаанд авлига үүсэхэд нөлөөлөх хүчин зүйл, авлигын нөхцлийг бүрдүүлэх “цоорхой” буюу институцийн сул тал, авлига үүсэх боломжийг тодорхойлно. Өөрийн үнэлгээний судалгааг жил бүр явуулж, үр дүнг нэгтгэн гаргана. Судалгааны хамрах хугацаа нь хуанлийн нэг жил байна.

Ингэхдээ байгууллагын чиг үүргийн хэрэгжилтийн үйл явцыг холбогдох асуудлыг эхлэн боловсруулахаас эхлээд түүнийг хэрэгжүүлэх бүхий л үе шатыг хамруулан судална.

“Авлигын эсрэг” Монгол Улсын хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6-д “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” гэж авлигын шалтгаан, нөхцлийг судлан тогтоох, тэдгээрийг арилгах, авлигыг таслан зогсоход чиглэгдсэн арга хэмжээний цогцолбор”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12-д төрийн байгууллага авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх

чиглэлээр “бүрэн эрхийнхээ хүрээнд авлигын шалтгаан нөхцлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг нь арилгах арга хэмжээ авах” гэсэн заалт нь төрийн байгууллага авлигын эрсдлийн үнэлгээний судалгаа явуулах эрх зүйн үндэс болно.

### **III.6. Баримтын судалгааны зорилго, хамрах хүрээ**

Баримтын судалгаагаар тухайн жилд бүртгэсэн авлигын эрх зүйн зөрчлийн тоон үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж, авлигын индексийн бүрдэл хэсгүүд болох авлигын цар хүрээ, хэлбэрийн үзүүлэлтүүдийг тодорхойлно. Баримтын судалгааг жил бүр явуулж, үр дүнг нэгтгэн гаргана. Судалгааны хамрах хугацаа хуанлийн нэг жил байна.

Баримтын судалгаагаар дараахь баримтад дүн шинжилгээ хийж авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааны үзүүлэлтийг тооцно. Үүнд:

- 1 Бүртгэсэн авлигын гэмт хэргийн статистикийн үзүүлэлтүүд, авлигатай холбогдох бүртгэгдсэн эрх зүйн зөрчлийн талаарх мэдээлэл
- 2 Авлигатай тэмцэх газрын гомдол, мэдээлэл хариуцсан нэгжид ирүүлсэн авлига, хүнд сурталтай холбогдох гомдлын талаарх мэдээлэл
- 3 Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны тайлан, мэдээлэл
- 4 Хууль, хяналтын байгууллагын шалгалтын дүн, зөвлөмж, дүгнэлт холбогдох бусад мэдээлэл
- 5 Улсын нэгдсэн төсвийн талаарх статистикийн мэдээлэл зэрэг албан ёсны статистикийн мэдээлэл
- 6 Шаардлагатай албан ёсны бусад мэдээлэл.



## ДӨРӨВ. АВЛИГЫН ИНДЕКС, ТҮҮНИЙГ ТООЦОХ АРГА ЗҮЙ

Авлигын индекс нь тодорхой нутаг дэвсгэр (аймаг, нийслэл), төрийн захиргааны байгууллага (яам, агентлаг) дахь авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг тодорхойлох тоон болон чанарын үзүүлэлтүүдийн нийлбэр цогц юм.

Тоон болон чанарын үзүүлэлтүүдийг индексжүүлэх буюу харьцуулагдахуйц хэлбэрт хувиргахдаа дараахь аргаас сонгож хэрэглэнэ. Үүнд:

1. Хувь, харьцаа зэрэг үзүүлэлтийг тооцох замаар үнэмлэхүй үзүүлэлтийг харьцангуй үзүүлэлтэд хувиргах;

2. Үзүүлэлтийн бодит утга болон үзүүлэлтийн бага утга (эсвэл байж болох доод хязгаар)-ын ялгаврыг үзүүлэлтийн их утга (эсвэл хүрэх түвшин) болон үзүүлэлтийн бага утга (эсвэл байж болох доод хязгаар)-ын ялгаварт харьцуулж харьцангуй үзүүлэлтийг тооцох;

3. Чанарын үзүүлэлт тус бүрийг үнэлж оноо өгөх замаар тоон үзүүлэлтэд шилжүүлэх.

Авлигын индексийн тоон үзүүлэлт нь авлигын цар хүрээ, хэлбэрийн үзүүлэлтийн арифметикийн дундаж байна. Авлигын индекс нь 0-1 хүртэлх утгыг авах бөгөөд индексийн утга 1-д ойртох тусам авлига багасч байна гэж үзнэ. Тухайлбал, авлигын хэлбэрийн үзүүлэлтийн утга нэмэгдэж байвал авлигын хүнд хэлбэрүүд үгүй болж байна гэж үзнэ.

### IV.1. Авлигын цар хүрээний үзүүлэлт

**1.1 Авлигын цар хүрээний талаарх олон нийт, шинжээчдийн төсөөллийн үзүүлэлт:** Уг үзүүлэлт нь авлига Монгол Улсад түгээмэл үзэгдэл болж байна гэж үзсэн олон нийт, шинжээчдийн хувийн жингээр авлигын тархацын талаарх төсөөллийг харуулна. Авлига түгээмэл үзэгдэл гэж үзсэн шинжээчдийн тоог судалгаанд хамрагдсан нийт шинжээчдийн тоонд харьцуулж “Авлига түгээмэл үзэгдэл гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувийн жин”-г тооцно. “Авлига түгээмэл үзэгдэл гэж үзсэн олон нийтийн эзлэх хувийн жин”-г үүнтэй адилаар тооцно.

*Тооцох арга зүй:* Авлигын цар хүрээний төсөөллийн үзүүлэлт ( $S_1$ )

$$S_1 = (\text{Авлига түгээмэл үзэгдэл гэж үзсэн шинжээчдийн эзлэх хувийн жин} \times 0.6) + (\text{Авлига түгээмэл үзэгдэл гэж үзсэн олон нийтийн эзлэх хувийн жин} \times 0.4)$$

*Мэдээллийн эх үүсвэр:* Авлигын талаарх олон нийт, шинжээчдийн төсөөллийн судалгааны дүн.

**1.2 Авлигын эдийн засгийн үр дагаврын үзүүлэлт:** Уг үзүүлэлт нь авлигын гэмт хэргийн улмаас тухайн жилийн улсын нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэлийн хэдэн хувьтай тэнцэх хэмжээний хохирол бий болсныг харуулна.

Авлигын гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад тогтоосон хэмжээгээр тооцно.

Тооцох арга зүй: Авлигын эдийн засгийн үр дагаврын үзүүлэлт ( $S_2$ )

$$S_1 = \frac{\text{Тухайн жилд авлигын гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ}}{\text{Тухайн жилийн улсын нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл}}$$

Мэдээллийн эх үүсвэр: Баримтын судалгаа буюу АТГ-ын мэдээлэл, улсын нэгдсэн төсвийн статистикийн мэдээлэл.

**1.3 Шинжээчдийн төсөөллөөрх авлигын хувь хэмжээ:** Уг үзүүлэлт нь шинжээчдийн төсөөллөөр тодорхой төрлийн хэлцлийн үнийн дүнгийн хэдэн хувьтай тэмцэх хэмжээний зардлыг авлигад зарцуулж буйг харуулна. Шинжээчдийн төсөөллийн судалгаанд дараах төрлийн хэлцлийг хамруулна. Үүнд:

1. Төрийн байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрт хамрагдах
2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах шалгаруулалтад ялах
3. Өр төлбөр, иргэний нэхэмжлэлийг шийдвэрлүүлэх
4. Татвараас чөлөөлүүлэх
5. Мөнгөн дүнгээр илэрхийлж болох, авлига үүсэх боломжтой бусад хэлцэл

Тооцох арга зүй: Шинжээчдийн төсөөллөөр дээр дурьдсан хэлцэл тус бүрийн үнийн дүн дэх авлигад зарцуулж буй зардлын эзлэх хувийн арифметикийн жигнэсэн дунджийг тооцно. Үнийн дүнд эзлэх эзлэх хувийг 5.0 хувь хүртэл, 5.1-10.0 хувь, 10.1-15.0 хувь, 15.1-20.0 хувь, 20.1 хувь болон түүнээс дээш гэсэн 5 бүлгээр ангилна.

Хэлцэл тус бүрээр авлигын хувь хэмжээг дараахь байдлаар тодорхойлно.

$$CP(i) = \frac{X_1 \cdot 2.5 + X_2 \cdot 7.5 + X_3 \cdot 12.5 + X_4 \cdot 17.5 + X_5 \cdot 22.5}{10000}$$

Энд:  $CP(i)$  –  $i$  дүгээр хэлцэл дэх авлигын хувь хэмжээ

$X_1$  - 1-р бүлгийг сонгосон судалгаанд оролцогчдын эзлэх хувь

$X_2$  - 2-р бүлгийг сонгосон судалгаанд оролцогчдын эзлэх хувь

$X_3$  - 3-р бүлгийг сонгосон судалгаанд оролцогчдын эзлэх хувь

$X_4$  - 4-р бүлгийг сонгосон судалгаанд оролцогчдын эзлэх хувь

$X_5$  - 5-р бүлгийг сонгосон судалгаанд оролцогчдын эзлэх хувь

Шинжээчдийн төсөөллөөр авлигын хувь хэмжээ ( $S_3$ )-г дараахь томъёогоор тооцно.

$$S_3 = \frac{\sum_{i=1}^n CP(i)}{n}$$

Энд:  $CP(i)$  –  $i$  дүгээр хэлцэл дэх авлигын хувь хэмжээ

$n$  – Шинжээчдийн судалгаанд авч үзсэн хэлцлийн тоо

*Мэдээллийн эх үүсвэр:* Авлигын талаарх шинжээчдийн төсөөллийн судалгааны дүн.

**1.4 Олон нийтийн зүгээс төрийн албан хаагчдад өгсөн хээл хахуулийн дундаж хувь хэмжээ:** Уг үзүүлэлт нь олон нийт төрийн үйлчилгээ авах, төрийн байгууллагын үйл ажиллагаатай холбогдох асуудлыг шийдвэрлүүлэхдээ өрхийн жилийн орлогынхоо дунджаар хэдэн хувийг зарцуулсныг харуулна.

*Тооцох арга зүй:* Төрийн үйлчилгээ авах, төрийн байгууллагын үйл ажиллагаатай холбогдох асуудлыг шийдвэрлүүлэхээр олон нийтийн өгсөн хээл хахуулийн хэмжээ нь өрхийн жилийн мөнгөн болон мөнгөн бус орлогын нийт дүнд эзлэх хувийг 1.0 хүртэл хувь, 1.1-3.0 хувь, 3.1-5.0 хувь, 5.1-10.0 хувь, 10.1-15.0 хувь, 15.1-25.0 хувь, 25.1-35.0 хувь, 35.1-50.0 хувь, 50.1-75.0 хувь, 75.1-100.0 хувь, 100.1 хувь болон түүнээс дээш гэсэн 11 бүлгээр ангилна.

Хээл хахуулийн дундаж хувь хэмжээ ( $S_4$ )

$$S_4 = \frac{X_1 \cdot 0.5 + X_2 \cdot 2.0 + X_3 \cdot 4.0 + X_4 \cdot 7.5 + X_5 \cdot 12.5 + X_6 \cdot 20.0 + X_7 \cdot 30.0 + X_8 \cdot 42.5 + X_9 \cdot 62.5 + X_{10} \cdot 87.5 + X_{11} \cdot 122.5}{10000}$$

Энд:  $X_1$  - 1-р бүлгийг сонгосон судалгаанд оролцогчдын эзлэх хувь

$X_2$  - 2-р бүлгийг сонгосон судалгаанд оролцогчдын эзлэх хувь

$X_3$  - 3-р бүлгийг сонгосон судалгаанд оролцогчдын эзлэх хувь

$X_4$  - 4-р бүлгийг сонгосон судалгаанд оролцогчдын эзлэх хувь

$X_5$  - 5-р бүлгийг сонгосон судалгаанд оролцогчдын эзлэх хувь

$X_6$  - 6-р бүлгийг сонгосон судалгаанд оролцогчдын эзлэх хувь

$X_7$  - 7-р бүлгийг сонгосон судалгаанд оролцогчдын эзлэх хувь

$X_8$  - 8-р бүлгийг сонгосон судалгаанд оролцогчдын эзлэх хувь

$X_9$  - 9-р бүлгийг сонгосон судалгаанд оролцогчдын эзлэх хувь

$X_{10}$  - 10-р бүлгийг сонгосон судалгаанд оролцогчдын эзлэх хувь

$X_{11}$  - 11-р бүлгийг сонгосон судалгаанд оролцогчдын эзлэх хувь

*Мэдээллийн эх үүсвэр:* Авлигын талаарх олон нийтийн төсөөллийн судалгааны дүн.

**Авлигын цар хүрээний нэгдсэн үзүүлэлт:** Энэ нь авлигын цар хүрээг илтгэн харуулах нэгдсэн үзүүлэлт юм.

*Тооцох арга зүй:* Авлигын цар хүрээний нэгдсэн үзүүлэлт ( $C_1$ )-ийг авлигын цар хүрээний үзүүлэлтүүдийн арифметикийн дунджийг нэгээс хасч тооцно.

$$C_1 = 1 - \frac{S_1 + S_2 + S_3 + S_4}{4}$$

Энд:  $C_1$  – Авлигын цар хүрээний үзүүлэлт

$S_1$  – Авлигын цар хүрээний талаарх иргэд, шинжээчдийн төсөөллийн үзүүлэлт

$S_2$  – Авлигын эдийн засгийн үр дагаврын үзүүлэлт

$S_3$  – Шинжээчдийн төсөөллөөрх авлигын хувь хэмжээ

$S_4$  – Олон нийтийн зүгээс төрийн албан хаагчдад өгсөн хээл хахуулийн дундаж хувь хэмжээ

## IV. 2. Авлигын хэлбэрийн үзүүлэлт

**2.1 Давхар объекттой авлигын гэмт хэргийн эзлэх хувь:** Уг үзүүлэлт нь нийт авлигын гэмт хэргийн дүнд давхар объекттой буюу хэд хэдэн эрх ашигт гэм хор учруулсан авлигын гэмт хэргийн эзлэх хувийн жинг харуулна. Авлигын гэмт хэргийн нийт тоо нь тухайн жилд АТГ-ын холбогдох нэгжид бүртгэгдсэн гэмт хэргийн нийт тоог хамруулна.

*Тооцох арга зүй:* Давхар объекттой авлигын гэмт хэргийн эзлэх хувь ( $N_1$ )

$$N_1 = \frac{\text{Давхар объекттой авлигын гэмт хэргийн тоо}}{\text{Авлигын гэмт хэргийн нийт тоо}}$$

*Мэдээллийн эх үүсвэр:* Баримтын судалгаа буюу АТГ-ын мэдээлэл.

**2.2. Хоёр болон түүнээс дээш давталттай авлигын гэмт хэргийн эзлэх хувь:** Уг үзүүлэлт нь нийт авлигын гэмт хэргийн дүнд хоёр болон түүнээс дээш давталттай буюу хэд хэдэн үйлдэлтэй авлигын гэмт хэргийн эзлэх хувийн жинг харуулна.

*Тооцох арга зүй:* Хоёр болон түүнээс дээш давталттай авлигын гэмт хэргийн эзлэх хувь ( $N_2$ )

$$N_2 = \frac{\text{Хоёр болон түүнээс дээш үйлдэлтэй авлигын гэмт хэргийн тоо}}{\text{Авлигын гэмт хэргийн нийт тоо}}$$

*Мэдээллийн эх үүсвэр:* Баримтын судалгаа буюу АТГ-ын мэдээлэл.

**2.3. Зохион байгуулалттай авлигын гэмт хэргийн эзлэх хувь:** Уг үзүүлэлт нь нийт авлигын гэмт хэргийн дүнд зохион байгуулалттайгаар үйлдэгдсэн авлигын гэмт хэргийн эзлэх хувийн жинг харуулна.

*Тооцох арга зүй:* Зохион байгуулалттай авлигын гэмт хэргийн эзлэх хувь ( $N_3$ )

$$N_3 = \frac{\text{Зохион байгуулалттай авлигын гэмт хэргийн тоо}}{\text{Авлигын гэмт хэргийн нийт тоо}}$$

*Мэдээллийн эх үүсвэр:* Баримтын судалгаа буюу АТГ-ын мэдээлэл.

**2.4. Авлигын гэмт хэргийн ангиллын үзүүлэлт:** Уг үзүүлэлт нь авлигын гэмт хэргийн тоог хөнгөн, хүндэвтэр, хүнд гэсэн ангиллаар үнэлсэн дундаж үнэлгээ юм.

Тооцох арга зүй: Авлигын гэмт хэргийн ангиллын үзүүлэлт ( $N_4$ )

$$N_4 = \frac{((\text{Хөнгөн гэмт хэргийн тоо} \times 0.05) + (\text{Хүндэвтэр гэмт хэргийн тоо} \times 0.30)) + (\text{Хүнд гэмт хэргийн тоо} \times 0.65)}{\text{Авлигын гэмт хэргийн нийт тоо}}$$

Мэдээллийн эх үүсвэр: Баримтын судалгаа буюу АТГ-ын мэдээлэл.

**2.5. Авлигын гэмт хэргийн шунахайн сэдэлтийн үзүүлэлт:** Уг үзүүлэлт нь нийт авлигын гэмт хэргийн дүнд шунахайн сэдэлттэйгээр үйлдэгдсэн гэмт хэргийн эзлэх хувийн жинг харуулна.

Тооцох арга зүй: Авлигын гэмт хэргийн сэдэлтийн үзүүлэлт ( $N_5$ )

$$N_5 = \frac{\text{Шунахайн сэдэлтэй авлигын гэмт хэргийн тоо}}{\text{Авлигын гэмт хэргийн нийт тоо}}$$

Мэдээллийн эх үүсвэр: Баримтын судалгаа буюу АТГ-ын мэдээлэл.

**Авлигын хэлбэрийн нэгдсэн үзүүлэлт:** Уг үзүүлэлт нь авлигын хэлбэрийн байдлыг илтгэн харуулах нэгдсэн үзүүлэлт юм.

Тооцох арга зүй: Авлигын хэлбэрийн нэгдсэн үзүүлэлт ( $C_2$ )-ийг авлигын хэлбэрийн үзүүлэлтүүдийн арифметик дунджийг нэгээс хасч тооцно.

$$C_2 = 1 - \frac{N_1 + N_2 + N_3 + N_4 + N_5}{5}$$

Энд:  $C_2$  – Авлигын хэлбэрийн үзүүлэлт

$N_1$  – Давхар объекттой авлигын гэмт хэргийн эзлэх хувь

$N_2$  – Хоёр болон түүнээс дээш давталттай авлигын гэмт хэргийн эзлэх хувь

$N_3$  – Зохион байгуулалттай авлигын гэмт хэргийн эзлэх хувь

$N_4$  – Авлигын гэмт хэргийн ангиллын үзүүлэлт

$N_5$  – Авлигын гэмт хэргийн шунахайн сэдэлтийн үзүүлэлт

### IV.3. Авлигын индексийг тооцох

Авлигын индексийг түүнийг бүрдүүлэгч хэсгүүд болох авлигын цар хүрээ, хэлбэрийн үзүүлэлтийн арифметикийн дунджаар тооцно. Авлигын индекс (MCI)-ийг дараах ерөнхий томъёогоор тооцно.

$$MCI / MAI = \frac{C_1 + C_2}{2}$$

Энд: MCI /MAI– Монгол Улсын авлигын индекс

$C_1$  – Авлигын цар хүрээний үзүүлэлт

$C_2$  – Авлигын хэлбэрийн үзүүлэлт

ЭХ Загвар

## ТАВ. АВЛИГЫН ИНДЕКСИЙН ҮР ДҮНГ АШИГЛАХ, НИЙТЭД ТАРААХ

Авлигын индекс нь авлигын төлөв байдлын цаг хугацаа, орон зайн өөрчлөлтийг харуулах учир авлигын индексийн тооцоо, холбогдох танилцуулга нь цаг хугацаа, орон зайн харьцуулалтад үндэслэсэн байна. Авлигын индексийг олон нийтэд тархаах /мэдээлэх/-даа түүний бүрэлдэхүүн хэсгүүд болох авлигын цар хүрээ, хэлбэрийн үзүүлэлтүүд, тэдгээрийн нэгдсэн үзүүлэлтүүдийн түвшинд харуулна. Авлигын индексийг таслалаас хойш 2 орны түвшинд гаргана. Авлигын индексийн талаарх танилцуулгад дараах асуудлыг тусгасан байна. Үүнд:

1. Авлигын индекс, түүний цаг хугацаа, орон зайн өөрчлөлт;
2. Авлигын цар хүрээ, хэлбэрийн үзүүлэлт, тэдгээрийн цаг хугацаа, орон зайн өөрчлөлт;
3. Авлигын индекс, авлигын цар хүрээ, хэлбэрийн үзүүлэлтийн өөрчлөлтөд нөлөөлсөн хүчин зүйлсийн шинжилгээ;
4. Авлигын индекст тулгуурласан дүгнэлт, санал зөвлөмж;
5. Авлигын индексийн тооцооны арга зүйд гарсан өөрчлөлт зэргийг тусгасан байна;
6. Хавсралт, хүснэгт зэргийг оруулна.

Авлигын индексийг тооцоход ашигласан задгай тоо мэдээллийг индексийн танилцуулгад оруулахгүй, зөвхөн АТГ-ын дотоод албан хэрэгцээнд ашиглана.

-----oOo-----

## ХАВСРАЛТ

### Авлигын индексийг тооцох хийсвэр жишээ

“Авлигын индекс тооцох аргачлал”-ын дагуу авлигын индексийг хийсвэр тоо мэдээлэлд үндэслэн авлигын 2008 оны байдлаар тооцсон гэж үзье.

#### 1. Авлигын цар хүрээний үзүүлэлтийн тооцоо

**1.1 Авлигын цар хүрээний талаарх олон нийт, шинжээчдийн төсөөллийн үзүүлэлтийн тооцоо:** Олон нийтийн төсөөллийн 2008 оны судалгаагаар судалгаанд хамрагдсан иргэд, төрийн албан хаагчид, бизнес эрхлэгчдийн 85.0 хувь нь авлига Монгол Улсад түгээмэл үзэгдэл гэж үзсэн бөгөөд Шинжээчдийн төсөөллийн 2008 оны судалгаанд хамрагдсан шинжээчдийн 60.0 хувь нь авлига түгээмэл үзэгдэл гэж үзсэн гэвэл Авлигын цар хүрээний талаарх олон нийт, шинжээчдийн төсөөллийн үзүүлэлтийг дараахь байдлаар тооцно.

$$S_1 = (0.85 \times 0.4) + (0.60 \times 0.6) = 0.34 + 0.36 \\ = 0.70$$

Авлигын цар хүрээний талаарх олон нийт, шинжээчдийн төсөөллийн үзүүлэлт 2008 оны байдлаар 0.70 гарч байна. Өөрөөр хэлбэл, олон нийт шинжээчдийн дунджаар 70.0 хувь нь авлига Монгол Улсад түгээмэл үзэгдэл гэж үзсэн байна гэсэн дүн гарчээ.

**1.2 Авлигын эдийн засгийн үр дагаврын үзүүлэлтийн тооцоо:** Мөрдөн шалгасан гэмт хэргийн улмаас 2008 онд 31163.9 сая төгрөгийн хохирол учирсан бол улсын нэгдсэн төсвийн зарлагын хэмжээ 2462046.6 сая төгрөг байжээ. Эндээс Авлигын эдийн засгийн үр дагаврын үзүүлэлтийг тооцвол дараахь байдалтай байна.

$$S_2 = \frac{31163.9}{2462046.6} = 0.013$$

Авлигын эдийн засгийн үр дагаврын үзүүлэлт 2008 оны байдлаар 0.013 гарчээ. Өөрөөр хэлбэл, улсын нэгдсэн төсвийн зарлагын 1.3 хувьтай тэнцэх хэмжээний хохирол авлигын гэмт хэргийн улмаас бий болсныг илтгэж байна.

**1.3 Шинжээчдийн төсөөллөөрх авлигын хувь хэмжээний тооцоо:** Шинжээчдийн төсөөллөөр тодорхой төрлийн хэлцлийн үнийн дүнгийн хэдэн хувьтай тэмцэх хэмжээний зардлыг авлигад зарцуулж байгаа талаарх мэдээллийг дараахь хүснэгтэд харуулав.



### Хүснэгт 1. Шинжээчдийн төсөөллөөр хэлцлүүдийн үнийн дүнд авлигын эзлэх хувь

Хэлцлүүд	Авлигад зарцуулдаг хувь	Авлигад зарцуулдаг дундаж хувь (интервалын дундаж)	Тухайн бүлгийг сонгосон шинжээчдийн эзлэх хувь	3=(1) x (2)
А	Б	1	2	3
Төрийн байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрт хамрагдах (CP <sub>1</sub> )	5.0 хувь хүртэл	2.5	48.5	121.3
	5.1-10.0 хувь	7.5	20.5	153.8
	10.1-15.0 хувь	12.5	15.2	190.0
	15.1-20.0 хувь	17.5	10.2	178.5
	20.1 хувь болон түүнээс дээш хувь	22.5	5.6	126.0
				<b>Дүн</b>
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах шалгаруулалтад ялах (CP <sub>2</sub> )	5.0 хувь хүртэл	2.5	30.2	75.5
	5.1-10.0 хувь	7.5	38.8	291.0
	10.1-15.0 хувь	12.5	15.2	190.0
	15.1-20.0 хувь	17.5	10.2	178.5
	20.1 хувь болон түүнээс дээш хувь	22.5	5.6	126.0
				<b>Дүн</b>
Өр төлбөр, иргэний нэхэмжлэлийг шийдвэрлүүлэх (CP <sub>3</sub> )	5.0 хувь хүртэл	2.5	7.0	17.5
	5.1-10.0 хувь	7.5	13.8	103.5
	10.1-15.0 хувь	12.5	15.2	190.0
	15.1-20.0 хувь	17.5	59.8	1046.5
	20.1 хувь болон түүнээс дээш хувь	22.5	4.2	94.5
				<b>Дүн</b>
Татвараас чөлөөлүүлэх (CP <sub>4</sub> )	5.0 хувь хүртэл	2.5	5.7	14.3
	5.1-10.0 хувь	7.5	50.2	376.5
	10.1-15.0 хувь	12.5	15.2	190.0
	15.1-20.0 хувь	17.5	25.8	451.5
	20.1 хувь болон түүнээс дээш хувь	22.5	3.1	69.8
				<b>Дүн</b>

Дээрх хүснэгтээс хэлцэл тус бүрээр авлигын хувь хэмжээг тодорхойлбол дараахь байдалтай байна.

$$CP_1 = \frac{769.5}{10000} = 0.08$$

$$CP_2 = \frac{861.0}{10000} = 0.09$$

$$CP_3 = \frac{1452.0}{10000} = 0.15$$

$$CP_4 = \frac{1102.0}{10000} = 0.11$$

Шинжээчдийн төсөөллөөрх авлигын хувь хэмжээний үзүүлэлтийг тооцвол дараахь байдалтай байна.

$$S_3 = \frac{\sum_{i=1}^n CP(i)}{n} = \frac{0.08 + 0.09 + 0.15 + 0.11}{4} = 0.10$$

Шинжээчдийн төсөөллөөрх авлигын хувь хэмжээний үзүүлэлт 2008 оны байдлаар 0.10 гарсан байна.

**1.4 Олон нийтийн зүгээс төрийн албан хаагчдад өгсөн хээл хахуулийн дундаж хувь хэмжээний тооцоо:** Олон нийтийн төсөөллийн 2008 оны судалгаагаар олон нийтийн төрийн үйлчилгээ авах, төрийн байгууллагын үйл ажиллагаатай холбогдох асуудлыг шийдвэрлүүлэхдээ өрх жилийн орлогынхоо дунджаар хэдэн хувийг зарцуулсан талаарх дараахь үр дүн гарчээ гэж үзье.

### Хүснэгт 2. Олон нийтийн зүгээс төрийн албан хаагчдад өгсөн хээл хахуулийн өрхийн жилийн төсөвт эзлэх хувь

Төрийн албан хаагчдад төлсөн хээл хахуулийн өрхийн жилийн нийт орлогод эзлэх хувь	Төрийн албан хаагчдад төлсөн хээл хахуулийн өрхийн жилийн нийт орлогод эзлэх дундаж хувь (интервалын дундаж)	Тухайн бүлгийг сонгосон судалгаанд оролцогчдын эзлэх хувь	3=(1) x (2)
А	1	2	3
1 хувь хүртэл	0.5	24.8	12.4
1.1-3.0 хувь	2.0	18.2	36.4
3.1-5.0 хувь	4.0	15.2	60.8
5.1-10.0 хувь	7.5	10.2	76.5
10.1-15.0 хувь	12.5	8.2	102.5
15.1-25.0 хувь	20.0	7.5	150.0
25.1-35.0 хувь	30.0	6.0	180.0
35.1-50.0 хувь	42.5	5.2	221.0
50.1-75.0 хувь	62.5	3.2	200.0
75.1-100.0 хувь	87.5	1.0	87.5
100.1 хувь болон түүнээс дээш хувь	122.5	0.5	61.3
<b>Дүн</b>		<b>100.0</b>	<b>1188.4</b>

Эндээс олон нийтийн зүгээс төрийн албан хаагчдад өгсөн хээл хахуулийн дундаж хувийг тооцвол дараахь байдалтай байна.

$$S_4 = \frac{1188.4}{10000} = 0.12$$

Энэ нь 2008 онд төрийн албан хаагчдад олон нийт дунджаар өрхийн жилийн орлогынхоо 11.9 хувийг хээл хахууль байдлаар өгснийг илтгэж байна.

**Авлигын цар хүрээний нэгдсэн үзүүлэлтийн тооцоо:** Дээрх тоо мэдээлэлд үндэслэн авлигын цар хүрээний нэгдсэн үзүүлэлтийг дараахь томъёогоор тооцно.

$$C_1 = 1 - \frac{S_1 + S_2 + S_3 + S_4}{4} = 1 - \frac{0.70 + 0.01 + 0.10 + 0.12}{4} = 0.77$$

Авлигын цар хүрээний үзүүлэлт 2008 оны байдлаар 0.77 гарч байна.

## 2. Авлигын хэлбэрийн үзүүлэлтийн тооцоо

**2.1 Давхар объекттой авлигын гэмт хэргийн эзлэх хувь:** Авлигатай тэмцэх газарт 2008 онд 331 гэмт хэрэг бүртгэгдснийг мөрдөн шалгажээ. Эдгээр гэмт хэргийн 102 нь давхар объекттой гэмт хэрэг байсан гэж үзье.

Эндээс Давхар объекттой авлигын гэмт хэргийн эзлэх хувь ( $N_1$ )-ийг тооцвол:

$$N_1 = \frac{\text{Давхар объекттой авлигын гэмт хэргийн тоо}}{\text{Авлигын гэмт хэргийн нийт тоо}} = \frac{102}{331} = 0.31$$

Давхар объекттой авлигын гэмт хэргийн эзлэх хувь ( $N_1$ ) 2008 оны байдлаар 0.31 гарчээ. Өөрөөр хэлбэл, 2008 онд бүртгэгдсэн авлигын гэмт хэргийн 30.8 хувь нь давхар объекттой гэмт хэрэг байсан гэсэн үг юм.

**2.2. Хоёр болон түүнээс дээш давталттай авлигын гэмт хэргийн эзлэх хувь:** 2008 онд 331 гэмт хэрэг бүртгэгдсний 68 нь хоёр болон түүнээс дээш үйлдэлтэй гэмт хэрэг байсан гэж үзье.

Эндээс хоёр болон түүнээс дээш давталттай авлигын гэмт хэргийн эзлэх хувь ( $N_2$ )-ийг тооцвол:

$$N_2 = \frac{\text{Хоёр болон түүнээс дээш үйлдэлтэй авлигын гэмт хэргийн тоо}}{\text{Авлигын гэмт хэргийн нийт тоо}} = \frac{68}{331} = 0.21$$

Хоёр болон түүнээс дээш давталттай авлигын гэмт хэргийн эзлэх хувь ( $N_2$ ) 2008 оны байдлаар 0.21 гарчээ. Өөрөөр хэлбэл, 2008 онд бүртгэгдсэн авлигын гэмт хэргийн 20.5 хувь нь хоёр болон түүнээс дээш үйлдэлтэй гэмт хэрэг байсан гэсэн үг юм.

**2.3. Зохион байгуулалттай авлигын гэмт хэргийн эзлэх хувь:** 2008 онд бүртгэгдсэн нийт авлигын гэмт хэргийн 172 нь зохион байгуулалттайгаар үйлдэгдсэн авлигын гэмт хэрэг байсан гэж үзье.

Эндээс зохион байгуулалттай авлигын гэмт хэргийн эзлэх хувь ( $N_3$ )-ийг тооцвол:

$$N_3 = \frac{\text{Зохион байгуулалттай авлигын гэмт хэргийн тоо}}{\text{Авлигын гэмт хэргийн нийт тоо}} = \frac{172}{331} = 0.52$$

Зохион байгуулалттай авлигын гэмт хэргийн эзлэх хувь ( $N_3$ ) 2008 оны байдлаар 0.52 гарчээ. Өөрөөр хэлбэл, 2008 онд бүртгэгдсэн авлигын гэмт хэргийн 50.2 хувь нь зохион байгуулалттайгаар үйлдэгдсэн гэмт хэрэг байсан гэсэн үг юм.

**2.4. Авлигын гэмт хэргийн ангиллын үзүүлэлт:** 2008 онд бүртгэгдсэн авлигын гэмт хэргийн 198 нь хөнгөн, 103 нь хүндэвтэр, 30 нь хүнд ангиллын гэмт хэрэг байсан гэж үзье.

Эндээс авлигын гэмт хэргийн ангиллын үзүүлэлт ( $N_4$ )-ийг тооцвол:

$$N_4 = \frac{198 \cdot 0.05 + 103 \cdot 0.30 + 30 \cdot 0.65}{331} = \frac{60.3}{331} = 0.18$$

Авлигын гэмт хэргийн ангиллын үзүүлэлт ( $N_4$ ) 2008 оны байдлаар 0.18 гарч байна.

**2.5. Авлигын гэмт хэргийн шунахайн сэдэлтийн үзүүлэлт:** 2008 онд бүртгэгдсэн нийт авлигын гэмт хэргийн 260 нь шунахайн сэдэлттэйгээр үйлдэгдсэн гэмт хэрэг байсан гэж үзье.

Эндээс Авлигын гэмт хэргийн сэдэлтийн үзүүлэлт ( $N_5$ )-ийг тооцвол:

$$N_5 = \frac{\text{Шунахайн сэдэлтэй авлигын гэмт хэргийн тоо}}{\text{Авлигын гэмт хэргийн нийт тоо}} = \frac{260}{331} = 0.79$$

Авлигын гэмт хэргийн сэдэлтийн үзүүлэлт ( $N_5$ ) 2008 оны байдлаар 0.79 гарчээ. Өөрөөр хэлбэл, 2008 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 78.5 хувь шунахайн сэдэлттэй гэмт хэрэг байсан гэсэн үг юм.

**Авлигын хэлбэрийн нэгдсэн үзүүлэлтийн тооцоо:** Дээрх тоо мэдээлэлд үндэслэн авлигын хэлбэрийн нэгдсэн үзүүлэлтийг тооцвол:

$$C_2 = 1 - \frac{N_1 + N_2 + N_3 + N_4 + N_5}{5} = 1 - \frac{0.31 + 0.21 + 0.52 + 0.18 + 0.79}{5} = 0.60$$

Авлигын цар хүрээний үзүүлэлт 2008 оны байдлаар 0.60 гарч байна.

### 3. Авлигын индексийн тооцоо

Дээрх тооцоонд үндэслэн авлигын индексийг дараахь томъёогоор тооцвол:

$$MCI / MAI = \frac{C_1 + C_2}{2} = \frac{0.77 + 0.60}{2} = 0.68$$

Авлигын индекс (MCI) 2008 оны байдлаар 0.68 гарч байна.